



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/661

Есөнбулаг

Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс
хамгаалах байрны зардалд хөрөнгө гаргах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.1 дэх заалт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалт, 19.1.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 35 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.2, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын Улаан Загалмай нийгэмлэг, Үндэсний Хүмүүнлэгийн Байгууллагын Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөлд хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах "Түр хамгаалах байр"-ны зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. АМГАЛАНБААТАР